




# “НӨМӨР КРЕДИТ АССЕТ ТЗК” ХХК-ИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Тайлан бэлтгэсэн:

"Юнайтед Айр Файнэнс" ХХК (Хөрөнгө итгэмжлэн  
удирдагч)

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо,  
Соёлын Төв Өргөө /14200/, 10 давхар, 1005 тоот

Утас: +976-70122346; info@uaf.mn

Гарын үсэг:

Х.Маргад-Эрдэнэ /Түгээтгэх захирал/

Тайланг баталсан:

Гарын үсэг:

Н.Баасанхүү /"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн ТУЗ-ийн

дарга/



## Агуулга

---

1. ХБҮЦ-ны мэдээлэл .....	3
2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл .....	4
3. Төлөөлөн удирдах зөвлөл .....	5
4. Хавсралт - Аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлт .....	6

## 1. ХБҮЦ-НЫ МЭДЭЭЛЭЛ

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 8 дугаар сарын 10-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "СЗХ" гэх)-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас (цаашид "ХБҮЦ" гэх) гаргах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийн 100 хувь эзэмшлийн охин компани юм.

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) нь хараат бус 3 гишүүнтэй бөгөөд ТУЗ-ийн даргаар Н.Баасанхүү, хараат бус гишүүдээр Б.Рэнцэнханд, Б.Эрдэнэжаргал нар, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар "Юнайтед Айр Файнэнс" ХХК ажиллаж байна.

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр 10 тэрбум төгрөгийн дүн бүхий ХБҮЦ-ыг СЗХ-нд бүртгүүлж 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд амжилттай арилжсан бөгөөд 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлсэн.

### Хүснэгт 1. ХБҮЦ-ны ерөнхий мэдээлэл

Мэдээлэл	Үзүүлэлт
ХБҮЦ гаргагч	"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9011839181
Регистрийн дугаар	6862705
ХБҮЦ-ыг бүртгэсэн СЗХ-ны тогтоолын огноо	2022/09/21
ХБҮЦ-ыг бүртгэсэн авсан СЗХ-ны тогтоолын дугаар	452
ХБҮЦ-ны нэрлэсэн үнэ (төг.)	100,000
ХБҮЦ (ширхэг)	100,000
ХБҮЦ (сая төг.)	10,000
ХБҮЦ-ны хүүгийн хувь (жилийн)	17.5%
ХБҮЦ-ны хүү төлөх давтамж	Улирал бүр
ХБҮЦ-ны хүү тооцох хоног	365 хоног

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК нь ХБҮЦ-ны төлбөрийг Хүснэгт 2-т харуулсан хуваарийн дагуу төлнө.

### Хүснэгт 2. ХБҮЦ-ны төлөлтийн талаарх мэдээлэл

№	Огноо	Үлдэгдэл	Үндсэн төлбөр	Хүүгийн төлбөр
1	2023/01/18	10,000,000,000.00	-	441,095,890.41
2	2023/04/18	10,000,000,000.00	-	431,506,849.32
3	2023/07/18	10,000,000,000.00	-	436,301,369.86
4	2023/10/18	10,000,000,000.00	5,000,000,000.00	441,095,890.41
5	2024/01/18	5,000,000,000.00	-	220,547,945.21
6	2024/04/18	5,000,000,000.00	-	218,150,684.93
7	2024/07/18	5,000,000,000.00	-	218,150,684.93
8	2024/10/18	5,000,000,000.00	5,000,000,000.00	220,547,945.21
Нийт			10,000,000,000.00	2,627,397,260.27

## 2. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын мэдээлэл

ХБҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш тайлант хугацааны байдлаар хөрөнгийн багцын хэмжээ 7.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. ХБҮЦ-ны хөрөнгийн багцын ерөнхий шинж чанар

Хөрөнгийн багцын шинж чанар	2022.10.18	2022.12.31	Өөрчлөлт
Багцын үлдэгдэл	9,983,638,572.00	9,275,253,827.00	-7.1%
Зээлийн дундаж үлдэгдэл	18,053,595.97	17,144,646.63	-5.0%
Хамгийн өндөр дүнтэй 1 зээлийн багцад эзлэх хувь	2.69%	2.90%	7.6%
Хамгийн өндөр дүнтэй 10 зээлийн багцад эзлэх хувь	10.90%	12.45%	14.2%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Хүү /жил/	32.93%	32.66%	-0.8%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.ЗҮХ	64.67%	61.08%	-5.6%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Насжилт /сар/	9.00	11.02	22.4%
Багц дахь зээлүүдийн Ж.Д.Үлдэгдэл хугацаа /сар/	31.81	29.18	-8.3%
Сарын дундаж төлбөрийн дүн	993,371.68	1,067,266.09	7.4%
Зээлдэгчдийн сарын дундаж орлого	1,655,619.47	1,886,108.58	13.9%
Зээлийн тоо	553	541	-2.2%
Зээлдэгчийн төрөл	Иргэн	Иргэн	-
Барьцаа хөрөнгийн төрөл	Автомашин	Автомашин	-
Барьцаа хөрөнгийн үнэлгээ	16,742,915,000.00	16,830,720,000.00	0.5%
Чанаргүй зээлийн хувь	0.00%	0.24%	-
Багц дахь зээлүүдийн эргэн төлөлт Үүнээс:	-	1,920,714,343.77*	-
Зээлийн үндсэн төлбөр	-	1,274,209,467.00	-
Хүүгийн төлбөр	-	644,722,811.77	-
Нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр	-	1,782,065.00	-

\*Хөрөнгийн багц дахь зээлүүдийн 2022 оны 12 дугаар сарын эргэн төлөлт болох 823.77 сая төгрөгийг гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сарын 03-ны дотор тооцоо нийлж, баталгаажуулан хуваарьт өдөр ТЗК-д шилжүүлнэ.

2022 оны эцсийн байдлаар “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн харилцах дансны үлдэгдэл 38.11 сая төгрөг байна.

“Юнайтед Айр Файнэнс” ХХК нь “Нөмөр Кредит Ассет ТЗК” ХХК-ийн хөрөнгийн багцад өөрчлөлт орсон талаарх мэдээллийг Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, СЗХ-ны “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны тухай журам”-ын 11.3-т заасны дагуу СЗХ-нд мэдэгдэж ажилласан.

Хүснэгт 4. ХБҮЦ-ны хөрөнгөөр багцад орсон өөрчлөлтийн талаарх мэдээлэл

№	Өөрчлөлт орсон мэдээлэл	Зээлийн тоо	Зээлийн дүн
1	Хаагдсан	48	-
2	Хугацаа хэтэрсэн тул буцаан шилжүүлсэн	3	63,661,656.00
3	Багцад нэмж бүртгэсэн	39	629,486,378.00
	<b>Нийт</b>	<b>90</b>	<b>693,148,034.00</b>

### 3. Төлөөлөн удирдах зөвлөл

"Нөмөр Кредит Ассет ТЗК" ХХК-ийг "Нөмөр Кредит ББСБ" ХХК нь бүрэн эзэмшдэг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч нь ганц хувьцаа эзэмшигч "Нөмөр Кредит ББСБ" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг хэрэгжүүлэгч) байна.

2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 05/04 тоот шийдвэрээр Н.Баасанхүү, Б.Эрдэнэжаргал, Б.Рэнцэнханд нарыг ТУЗ-ийн гишүүнээр тус тус сонгож 2022 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн ТУЗ-ийн хурлаар Н.Баасанхүүг ТУЗ-ийн даргаар томилсон.

Тайлант хугацаанд ТУЗ нь бүрэн эрхийнхээ хүрээнд нийт 7 удаа хуралдаж холбогдох тогтоолыг баталсан. Үүнд:

Хүснэгт 5. ТУЗ-ийн шийдвэр, хэрэгжилт

№	Огноо	ТУЗ-ийн шийдвэрийн агуулга	Хэрэгжилт
1	2022.05.04	ТУЗ-ийн даргын томилох тухай ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах тухай	ТУЗ-ийн даргаар Н.Баасанхүүг томилж ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлав.
2	2022.05.05	Арилжааны банкинд данс нээх тухай	ХХБ харилцах данс нээж гарын үсэг зурах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
3	2022.05.27	Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох,солих тухай журмыг батлах тухай Компанийн аудитораар Мүүр аудит ХХК-ийг сонгох тухай.	Хөндлөнгийн аудитор, үйлчилгээ үзүүлэгч, хөрөнгө итгэмжлэн удирдагчийг сонгох,солих тухай журмыг батлав. Компанийн санхүүгийн тайланд аудит хийх компаниар Мүүр аудит ХХК-ийг сонгов.
4	2022.08.17	Нийтэд санал болгох ХБҮЦ-ны хэмжээ үнийн дүн шалгуур нөхцөлийг батлах, үнэт цаасны баталгаа болж буй зээлийн хөрөнгийн багцад тавих шалгуурыг батлах тухай. ХБҮЦ-ны хэлцэлтэй холбоотой гэрээ журмын төслийг батлах тухай.	Нийтэд санал болгох 10 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ны нөхцөлийг баталж, холбогдох журмыг батлав.
5	2022.08.18	Хэлцлийн оролцогч талуудыг баталгаажуулах тухай Сонирхолын зөрчилтэй их хэмжээний хэлцлийг батлах тухай	Оролцогч талуудыг баталгаажуулж тэдгээртэй гэрээ байгуулах эрхийг ТУЗ-ийн даргад олгов.
6	2022.08.19	Нийтэд санал болгох 10 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ны нөхцөлийг баталж СЗХ болон МХБ үнэт цаас гаргахтай холбоотой өргөдлийг хүргүүлэв.	Нийтэд санал болгох 10 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ны нөхцөлийг баталж СЗХ болон МХБ үнэт цаас гаргахтай холбоотой өргөдлийг хүргүүлэв.
7	2022.10.03	ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг сонгох тухай	ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Б.Нацагдолгорыг томилон.